

ЗАХИАЛАГЧ:  
УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ  
МЕНЕЖЕР БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



Ц.ТӨРХҮҮ

**УСНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АШИГЛАЛТ ЗАСВАРЫН ДҮРМИЙН  
АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 оны 10 сарын 04-ний өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

1.	Төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>- Монгол Улсын Их Хурлын 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртлэх чиг хандлага;</li><li>- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг;</li><li>- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;</li><li>- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр /3.7.12 заалт/;</li><li>- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;</li><li>- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 65 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө;</li><li>- Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалт;</li><li>- Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт;</li><li>- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн тогтолцоо”</li><li>- Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны 05 дугаар сарын 174-ний өдрийн А/97 дугаартай тушаал;</li><li>- Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх 24 байршлын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн засвар, шинэчлэл болон шинээр барих үерийн</li></ul>
----	-----------------------------------	--

		<p>хамгаалалтын барилга байгууламжийн ажлын зураг төсөл, судалгааны ажил боловсруулах ЗАА/ХТСИ-2024-A/97 дугаартай гэрээ</p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол улсын засгийн газрын 2017 оны 353-р тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм”</li> </ul>
2.	Төслөөр шийдвэрлэх асуудал	<ul style="list-style-type: none"> <li>- Энэхүү барилгын норм ба дүрмийг инженерийн бэлтгэл арга хэмжээтэй холбоотой усны барилга байгууламжийг үр ашигтай ашиглах, хяналт хийх, засварын ажлыг төлөвлөх, гүйцэтгэхэд дагаж мөрдөнө.</li> </ul>
3.	Төсөл боловсруулах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Хот суурин газрын инженерийн бэлтгэл арга хэмжээний усны барилга байгууламжийн ашиглалтын байдал хангалтгүй, засвар үйлчилгээний арга аргачлал тодорхойгүй, сайн хийгддэггүй зэрэг хүндрэлтэй нөхцөл байдал их байхаас гадна ашиглалт, засвар үйлчилгээ хийхэд баримтлах норм байхгүй учир үр ашиггүй хөрөнгө оруулалт хийгдэх, үерийн эрсдэл үүсэх нөхцөл бий болж байна. Иймд судалгаа, тооцооны үндэслэлтэй ашиглалт, засварын дүрэм, засвар арчлалтын төсвийн нормыг боловсруулах шаардлагатай байна.</li> <li>- Мөн усны барилга байгууламжийн төрлөөс хамаарч ашиглалтын дүрэм онцлогтой байх бөгөөд ашиглалтын горим, цэвэрлэгээ болон мониторингийн ажлуудыг хийх технологи, давтамж зэргийн талаар техникийн баримт бичгүүд байхгүй учир барилга байгууламжийн чанар муудах, хөрөнгө оруулалтын үр ашиг муудах, ашиглалтын хугацаа богиносх, үер усны эрсдэл үүсэх асуудлууд бий болж байна.</li> </ul>
4.	Төслийн бүрдэл	<p>Усны барилга байгууламжийн ашиглалт засварын дүрэм нь дараах хэсгүүдээс бүрдсэн байвал зохино.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хэрэглэх хүрээ</li> <li>2. Норматив эшлэл</li> <li>3. Нэр томъёо ба тодорхойлолт</li> <li>4. Ерөнхий зүйл</li> <li>5. Үндсэн хэсэг <ul style="list-style-type: none"> <li>- Усны барилга байгууламжийн ашиглалтын дүрэм (барилга байгууламж бүрээр)</li> <li>- Усны барилга байгууламжийн ашиглалтын түвшний үнэлгээ</li> <li>- Усны барилга байгууламжийн засварын ажлын дүрэм (барилга байгууламж бүрээр)</li> </ul> </li> <li>6. Ашигласан материал</li> <li>7. Хавсралтууд</li> </ol>
5.	Төслийг хэрэгжүүлэх байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>- Хот байгуулалт, Барилга, Орон сууцжуулалтын яам</li> <li>- Барилга хөгжлийн төв ТӨААТҮГ</li> </ul>

6.	Төслийг гүйцэтгэх байгууллага аж ахуйн нэгж	- Гүйцэтгэгчийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу сонгон шалгаруулна.
7.	Төслийг боловсруулж дуусах хугацаа	- 2025 оны I улирал
8.	Төсөлд шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	
9.	Төслийн онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн норм, нормативийн баримт бичгийн ерөнхий тогтолцоо"-ны шаардлагыг хангасан байх;</li> <li>- Салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа усны барилга байгууламжийн болон хот төлөвлөлт, барилга байгууламжийн норматив баримт бичгийн үг хэллэг, утга агуулгатай уялдаж нийцсэн байх, зөрчилдөхгүй байх;</li> <li>- Боловсруулагдаж байгаа баримт бичгийн төсөл нь техникийн даалгаврын төслийн бүрдэлд тусгагдсан агуулгатай байхаас гадна боловсруулалтын явцад төслийг ойлгомжтой, эмх цэгцтэй, нэмэлт мэдээлэл тусгагдахаар сайжруулалт хийх тохиолдолд өөрчлөлт орж болно;</li> <li>- Боловсруулагдаж байгаа баримт бичигтэй холбоотойгоор дагаж гарах баримт бичгийн жагсаалт, хүчингүй болгох баримт бичгийг захиалагчид зөвлөмж байдлаар ирүүлэх;</li> <li>- Дараах байгууллагуудаас санал авна. Үүнд: <ol style="list-style-type: none"> <li>1. Онцгой байдлын ерөнхий газар</li> <li>2. Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ</li> <li>3. Усны барилга байгууламжийн зураг төсөл, угсралтын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж</li> </ol> </li> <li>- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, хөх-ногоон аргачлал болон хөгжлийн бага нөлөөтэй шийдлүүдийг агуулсан, хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулсан техникийн болон зохион байгуулалтын дүрмүүдийг тусгана.</li> </ul>

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН  
АЖЛЫН АЛБАНЫ ХОТЫН ИНЖЕНЕРИЙН  
ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН ДАРГА

"ГЕОДЕЗИ, УСНЫ БАРИЛГА  
БАЙГУУЛАМЖИЙН ГАЗАР"  
ОНӨААТҮГ-ЫН ЕРӨНХИЙ  
ИНЖЕНЕР



М.БАЛДАНДОРЖ



С.БАТСАЙХАН

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН  
АЖЛЫН АЛБАНЫ ХОТЫН ИНЖЕНЕРИЙН  
ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН УСНЫ БАРИЛГА  
БАЙГУУЛАМЖ, ИНЖЕНЕРИЙН БЭЛТГЭЛ  
АРГА ХЭМЖЭЭ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН



Э.ТУНГАЛАГТАМИР

**ХАЯГ:** УЛААНБААТАР ХОТ, ХАН-УУЛ  
ДҮҮРЭГ, 23-Р ХОРОО, НААДАМЧДЫН ЗАМ,  
ХАНГАРДИ ОРДОН, Б/БЛОК, 8-Р ДАВХАРТ

**УТАС:** 11-31 54 29

**ХАЯГ:** УЛААНБААТАР ХОТ,  
БАЯНГОЛ ДҮҮРЭГ, 20 ДУГААР  
ХОРОО, МОСКВАГИЙН ГУДАМЖ, 75  
ТООТ

**УТАС:** 77200200